



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/37/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Азаяа

Утас: 99125777

цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.3 Албан шаардлага.....	15
5.4 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА Б.БАЯРЖАРГАЛ ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.14 № 2/30
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулах арга хэмжээ аваагүй, өдөрт ажиллах илүү цагийн дээд хязгаарыг баримтлаагүй, нэмэгдлийг бүх ажилчдад хавтгайруулан олгосон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой байгууллагын хэрэгцээнд ашиглаж байгаа 2 нэр төрлийн автомашины үнийг шинэчлэн тогтоогоогүй, тайлант хугацаанд худалдан авч зарцуулсан сумны зарцуулалтын тооцоо бодож баталгаажуулаагүй, бөөн дүнгээр зарлагадсан, албан хаагчдын томилолтоор ажилласан хугацааны хоолны хөнгөлөлтийг суутган тооцоогүй, зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 84.4. "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна.", 109.1. "Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчд эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020227

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор МоЭнКо ХХК-нд төлбөртэй үйлчилгээ үзүүлж 512.9 сая төгрөгийн орлогыг нэмэлт дансаар бүрдүүлж 443.2 сая төгрөгийг ажилчдын илүү цагийн нэмэгдэлд зарцуулж байгууллагын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл 40.2 сая төгрөгөөр, мөн хандив бусад эх үүсвэрээс автомашин 30.0, тоног төхөөрөмж 94.0, нийт 168.2 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудалгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 9 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 99.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор Эрүүл мэндийн яамны 2022.01.06-ны өдрийн 5/29 тоот албан бичгийн дагуу "Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал цахим хурал, Sars-Cov-2 вирусын омикрон хувилбарын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах нь сэдэвт сургалтад байгууллагын ажилчид хамрагдсан байна. ЗӨСҮТ-өөс зохион байгуулсан "Тарваган тахал өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдэвт зайн сургалтад байгууллагын бүх албан хаагчид хамрагдсан байна.

АДБОУС 2706.10-д зааснаар дархлаажуулалт, тархвар судлал, мал амьтаны устгалт зэрэг асуудлыг аудитын хамрах цаг хугацаанаас шалтгаалан аудитад хамруулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х. БОЛОРБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>54,229,061.2</u>	<u>193,015,871.4</u>
33	АВЛАГА	5,398,519.2	31,403,894.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,096,621.6	1,442,933.5
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	29,685,357.0
335	Бусад авлага	301,897.6	275,603.6
3351	Байгууллагаас авах авлага	301,897.6	275,603.6
34	УРЬДЧИЛГАА	211,813.0	211,813.0
3471	Урьдчилгаа тооцоо	211,813.0	211,813.0
34713	Цалингийн урьдчилгаа	211,813.0	211,813.0
35	БАРАА МАТЕРИАЛ	48,618,729.0	161,400,164.3
351	Түүхий эд материал	38,018,679.0	145,759,039.0
35130	Эм боох материал	38,018,679.0	145,759,039.0
354	Хангамжийн материал	10,600,050.0	15,641,125.3
35410	Бичиг хэргийн материал	150,000.0	230,000.0
35420	Аж ахуйн материал	254,096.0	-
35430	Сэлбэг хэрэгсэл	-	784,000.0
35470	Бусад хангамжийн материал	10,195,954.0	14,627,125.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>417,984,895.0</u>	<u>519,127,901.6</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	417,984,895.0	519,127,901.6
392	Биет хөрөнгө	230,841,769.9	330,734,776.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	54,780,140.0	54,780,140.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,767,215.2)	(46,724,140.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,828,000.0	145,828,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,969,777.7)	(76,815,777.7)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	270,065,083.5	402,440,282.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	(136,849,496.6)	(172,024,259.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,785,534.0	15,135,534.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,050,498.1)	(8,703,669.3)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,020,000.0	18,020,000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,201,333.3)
393	Биет бус хөрөнгө	187,143,125.0	188,393,125.1
39301	Програм хангамж	795,000.0	2,295,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(591,875.0)	(841,874.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,940,000.0	186,940,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>472,213,956.2</u>	<u>712,143,773.0</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>472,213,956.2</u>	<u>712,143,773.0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	472,213,956.2	712,143,773.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,955,180.0	275,955,180.0
51101	Өмч: - төрийн	275,955,180.0	275,955,180.0

512	Хуримтлагдсан үр дүн	52,442,425.2	292,372,242.0
51210	Өмнөх үеийн үр дүн	52,442,425.2	52,442,425.2
51220	Тайлант үеийн үр дүн	-	239,929,816.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	143,816,351.0	143,816,351.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	472,213,956.2	712,143,773.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	902,799,943.0	1,418,656,181.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,081,000.0	352,836,214.3
120	Нийтлэг татварын бус орлого	162,081,000.0	352,836,214.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162,081,000.0	352,836,214.3
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	162,081,000.0	352,836,214.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	740,718,943.0	1,065,819,967.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	450,402,200.0	493,601,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	450,402,200.0	493,601,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,124,212.0	572,218,267.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,344,893.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,779,319.0	572,218,267.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	192,531.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	192,531.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	820,488,680.1	1,178,726,364.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,488,680.1	1,178,726,364.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	787,740,766.1	1,154,617,911.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	475,519,537.2	745,465,518.6
210101	Үндсэн цалин	195,000,007.2	252,902,292.0
210102	Нэмэгдэл	237,441,194.4	440,649,455.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,987,999.6	15,893,943.0
210104	Урамшуулал	28,090,336.0	36,019,828.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,287,699.8	99,322,273.7
210201	Тэтгэврийн даатгал	44,284,060.8	84,782,773.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,858,785.9	3,376,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,184,728.6	3,597,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	632,657.2	686,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,327,467.2	6,878,600.0
2103	Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал	27,748,955.4	25,312,006.0
210301	Гэрэл, цахилгаан	1,771,447.4	1,677,694.0
210302	Түлш, халаалт	23,628,260.0	21,081,660.0
210303	Цэвэр, бохир ус	2,349,248.0	2,552,652.0
2104	Хангамж, бараа материалын зардал	37,550,068.0	37,612,306.0
210401	Бичиг хэрэг	4,041,389.0	5,096,100.0

210402	Тээвэр, шатахуун	26,807,333.0	27,358,215.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	685,200.0	653,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,000.0	1,819,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,981,146.0	2,685,491.0
2105	Нормативт зардал	127,094,690.0	146,237,978.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,132,090.0	144,395,980.0
210502	Хоол, хүнс	1,100,000.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,862,600.0	1,841,998.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,478,940.0	9,975,237.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,433,040.0	6,831,137.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	373,800.0
210604	Урсгал засвар	1,045,900.0	2,770,300.0
2107	Томилолт, зочны зардал	7,050,000.0	10,394,300.0
210702	Дотоод албан томилолт	7,050,000.0	10,394,300.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,536,300.0	2,486,100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.0	480,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.0	207,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.0	237,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	190,000.0	190,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,075,200.0	1,025,000.0
210807	Газрын төлбөр	96,000.0	96,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.0	250,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,474,575.7	77,812,192.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,730,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,474,575.7	67,082,192.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,747,914.0	24,108,452.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,395,062.0	14,000,000.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	385,062.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,010,000.0	14,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	352,852.0	10,108,452.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	352,852.0	10,108,452.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	82,311,262.9	239,929,816.8
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	82,311,262.9	239,929,816.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	740,718,943.0	1,036,134,610.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	740,718,943.0	1,036,134,610.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	450,402,200.0	493,601,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	450,402,200.0	493,601,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,124,212.0	542,532,910.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,344,893.0	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,779,319.0	542,532,910.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	192,531.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	192,531.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	740,718,943.0	1,036,134,610.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	740,718,943.0	1,036,134,610.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,971,029.0	1,012,026,157.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,751,746.0	743,451,477.1
210101	Үндсэн цалин	192,747,900.0	228,520,548.4
210102	Нэмэгдэл	243,227,546.0	462,939,208.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,939,000.0	15,648,000.0
210104	Урамшуулал	28,837,300.0	36,343,720.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,562,550.0	97,682,627.0
210201	Тэтгэврийн даатгал	41,146,150.0	81,197,595.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,083,300.0	7,041,232.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,549,900.0	2,518,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	616,700.0	629,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,166,500.0	6,295,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,420,648.0	25,285,712.0
210301	Гэрэл, цахилгаан	1,732,300.0	1,651,400.0
210302	Түлш, халаалт	28,319,100.0	21,290,992.0
210303	Цэвэр, бохир ус	2,369,248.0	2,343,320.0
2104	Хангамж, бараа материалын зардал	50,273,602.0	36,967,615.0
210401	Бичиг хэрэг	3,581,909.0	4,108,700.0
210402	Тээвэр, шатахуун	26,853,833.0	27,358,215.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	685,200.0	653,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.0	2,097,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,952,660.0	2,750,200.0
2105	Нормативт зардал	65,632,843.0	32,211,890.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,233,843.0	27,098,290.0
210502	Хоол, хүнс	1,100,000.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,299,000.0	5,113,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,507,000.0	52,816,436.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,560,000.0	47,174,636.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200,000.0	1,144,000.0
210604	Урсгал засвар	4,747,000.0	4,497,800.0
2107	Томилот, зочны зардал	7,050,000.0	10,394,300.0
210702	Дотоод албан томилот	7,050,000.0	10,394,300.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,536,300.0	2,486,100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.0	480,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.0	207,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.0	237,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	190,000.0	190,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,075,200.0	1,025,000.0
210807	Газрын төлбөр	96,000.0	96,000.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.0	250,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,236,340.0	10,730,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,236,340.0	10,730,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,747,914.0	24,108,452.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,395,062.0	14,000,000.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	385,062.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,010,000.0	14,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	352,852.0	10,108,452.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	352,852.0	10,108,452.9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	52,442,425.2	472,213,956.2
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	52,442,425.2	472,213,956.2
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	52,442,425.2	472,213,956.2
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	239,929,816.8	239,929,816.8
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	292,372,242.0	712,143,773.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	493,601,700.0	493,601,700.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	493,601,700.0	493,601,700.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,192,500.0	493,192,500.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,411,400.0	353,411,400.0
210101	Үндсэн цалин	225,318,200.0	225,318,200.0
210102	Нэмэгдэл	79,856,400.0	79,856,400.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,939,000.0	15,939,000.0
210104	Урамшуулал	32,297,800.0	32,297,800.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,926,400.0	42,926,400.0
210201	Тэтгэврийн даатгал	29,190,000.0	29,190,000.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,434,100.0	3,434,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,747,300.0	2,747,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	686,800.0	686,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,868,200.0	6,868,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,556,800.0	31,556,800.0
210301	Гэрэл, цахилгаан	1,651,400.0	1,651,400.0
210302	Түлш, халаалт	25,880,400.0	25,880,400.0
210303	Цэвэр, бохир ус	4,025,000.0	4,025,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,116,200.0	24,116,200.0
210401	Бичиг хэрэг	1,558,700.0	1,558,700.0

210402	Тээвэр, шатахуун	17,056,800.0	17,056,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	653,200.0	653,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,097,300.0	2,097,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,750,200.0	2,750,200.0
2105	Нормативт зардал	19,985,600.0	19,985,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,872,000.0	14,872,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,113,600.0	5,113,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,035,700.0	9,035,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,393,900.0	3,393,900.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,144,000.0	1,144,000.0
210604	Урсгал засвар	4,497,800.0	4,497,800.0
2107	Томилолт, зочны зардал	9,674,300.0	9,674,300.0
210702	Дотоод албан томилолт	9,674,300.0	9,674,300.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,486,100.0	2,486,100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.0	480,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	207,900.0	207,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.0	237,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	190,000.0	190,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,025,000.0	1,025,000.0
210807	Газрын төлбөр	96,000.0	96,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.0	250,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	409,200.0	409,200.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	409,200.0	409,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	409,200.0	409,200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	493,601,700.0	493,601,700.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	493,601,700.0	493,601,700.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	493,601,700.0	493,601,700.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	290,124,212.0	542,532,910.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,124,212.0	542,532,910.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,124,212.0	542,532,910.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		392,468,241.1
210101	Үндсэн цалин	499,500.0	4,471,001.4
210102	Нэмэгдэл	170,927,146.0	387,086,448.2
210104	Урамшуулал		910,791.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,855,250.0	55,756,227.0
210201	Тэтгэврийн даатгал	11,855,250.0	52,007,595.0
210202	Тэтгэмжийн даатгал		3,478,632.0

2104	Хангамж, бараа материалын зардал	27,109,602.0	12,851,415.0
210401	Бичиг хэрэг	1,946,909.0	2,550,000.0
210402	Тээвэр, шатахуун	11,060,033.0	10,301,415.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,102,660.0	
2105	Нормативт зардал	44,733,843.0	12,226,290.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,633,843.0	12,226,290.0
210502	Хоол, хүнс	1,100,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		43,780,736.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		43,780,736.0
2107	Томилолт, зочны зардал		720,000.0
210702	Дотоод албан томилолт		720,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,236,340.0	10,730,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,236,340.0	10,730,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,762,531.0	14,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		14,000,000.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	192,531.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,570,000.0	14,000,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	290,124,212.0	542,532,910.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,124,212.0	542,532,910.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,344,893.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,200,000.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,779,319.0	542,532,910.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь захиргаа аж ахуйн тасаг, голомт хяналтын тасаг, лабораторын тасагтай 24 ажилтантайгаар зооноз өвчний голомтыг судлах, тогтоох, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүний өвчлөлийг оношлох, өвчний голомтыг цомхотгох, халдваргүйжүүлэх үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн харьяа байгууллага юм.

ЗӨСТөвийн 2022 оны календарьчилсан төлөвлөгөөний дагуу 2022 онд аймгийн нийт сумдад тархвар судлал, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан.

Дарви, Зэрэг, Манхан, Цэцэг, Мөст, Алтай, Үенч, Булган, Дуут, Мөнххайрхан сумын ард иргэдээс тарваган тахал, хачигт халдвар өвчний асуумж судалгаа тус бүр 30 нийт 600 хүнээс, Мянгад, Буянт, Ховд, Эрдэнэбүрэн, Дөргөн сумын ард иргэдээс галзуу, боом өвчний асуумж судалгаа тус бүр 50 нийт 500 хүнээс судалгаа авч тархвар судлалын тандалт шинжилгээ хийсэн байна.

16 сумын ЗДТГ-ын дарга, сургуулийн захирал нартай уулзаж сумын онцгой комиссын гишүүд болон сумын нийт төрийн болон хувийн хэвшлийн алба хаагчдад зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зоонозын халдварт өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, ахлах ангийн сурагчдад хувь хүний хөгжлийн талаар болон зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зоонозын халдварт өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, голомт хяналтын эмч нарын гурвалсан гэрээг шинэчлэн хийж, голомт хяналтын эмч томилоогүй сумдад шинээр эмч томилон, ажил хавсран гүйцэтгэсний 20-30 хувийн нэмэгдэл цалин олгохоор тушаал гаргуулж заавар зөвлөмж өгч ажилласан.

Энэ хугацаанд нийт 16 удаагийн лекцэнд 1100 гаруй хүнд, 35 удаагийн яриа таниулгаар 365 хүнд зоонозын халдварт өвчний талаар, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хүргэж тарваган тахал, боом, галзуу, хачигт халдвар, шувууны томуу зэрэг урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж ард иргэд болон голомт хяналтын эмчид нийт 8755 ширхэг тараах материал тараасан байна.

Жаргалант, Эрдэнэбүрэн, Ховд сумдын 3 секторын 26709 га талбайг хамруулан боом өвчний тандалт шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Шинжилгээнд сэг зэм-18, үс ноос-20, хөрс бууц-60, цэвэр бохир ус-10, арьс шир-20, лангууны арчдас 72 зэрэг нийт 200 сорьцийг Захын буу, Шар нуур, Цагаан эрэг, Хөндий ам зэрэг газрууд болон Хан-Орд, Бугаан гол зэрэг хүнсний захаас цуглуулсан. Нийт цуглуулсан материалыг лабораторийн шинжилгээнд хамруулахад боом өвчний үүсгэгч илрээгүй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь эрүүл мэндийн тухай, эрүүл мэндийн даатгалын тухай, эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд эрүүл мэндийн тухай хуульд 5 удаа, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2 удаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт оржээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр** нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Мөн 2022 онд Ховд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020, 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дулааны шугамыг шинэчлэх ажилтай холбоотой 1.6 сая төгрөгийн зөрчилд акт тогтоосон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 239.9 сая төгрөгөөр буюу 49.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	5,398.5	31,403.8	26,005.3
Бараа материал	48,618.7	161,400.1	112,781.4
Үндсэн хөрөнгө	417,984.8	519,127.9	101,143.1
Нийт хөрөнгө	472,213.9	712,143.7	239,929.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	472,213.9	712,143.7	239,929.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	472,213.9	712,143.7	239,929.8

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дугаар сарын 07 өдрийн А/454 тушаалаар 95.6 сая төгрөгийн нүдний шил хамгаалалт 2022 оны 12 сард ирсэнээр бараа материалын үлдэгдэл өссөн байна.
- ✓ МоЭнКо ХХК-наас 2022 оны 12 сарын төлбөртэй үйлчилгээний авлага 29.7 сая төгрөгийг тооцоо нийлж авлагаар бүртгэсэн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 493.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн яамнаас 493.6 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 493.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 493.6 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн авч ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа 71601/80101	493,601.7	493,601.7	0	100
ДҮН		493,601.7	493,601.7	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны тайлангаар МоЭнКо ХХК-наас 512.9, Баатрын жинчид транс ХХК-наас 26.0, Зоонозын өвчин судлалын үндэсний төсвөөс 3.5 сая бүгд 542.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24 ажилтанд нийт 302.4 сая төгрөгийн илүү цагийн хөлс, НДШ-д 103.5, ХАОАТ-д 42.4, аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Микролайнс ХХК-наас тоног төхөөрөмж худалдан авахад 9.3, Занааспекс ХХК-наас тоног төхөөрөмж 11.0, аймгийн Засаг даргын А/411 захирамжаар лабораторын тоног төхөөрөмжинд 11.0 сая, нэг удаагийн тэтгэмжинд 14.0 сая, шатахуунд 10.3, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 12.2, Онцгой комиссын 63 дугаар тогтоолоор Дөргөн, Мөст, Эрдэнэбүрэн сумуудад гарсан гоц халдварт өвчинтэй тэмцэх албан хаагчдын шатахуун хоолны зардалд 10.7, бичиг хэрэгт 2.5, программ хангамжийн зардалд 1.5, НДШ, ХАОАТ-ын үндсэн цалингийн сангийн өр төлбөрт 27.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Азаяа 2023 оны 02 дугаар сарын 06-наас 02 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 1/07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,178,726.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.1 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 155 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 4 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж баталгаажуулж хэвших. Нэмэлт дансны орлого зарлагын мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлэх, Аймгийн онцгой комиссын шийдвэрээр гадна халаалтын шугам шинэчлэх ажлыг Ховдын хаш өргөө ХХК-тай 18.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд олгох санхүүжилтээс захиалагчийн хяналтын зардал 0.7 сая, магадлашгүй ажлын 0.4 сая төгрөгийг суутгаагүй зөрчил илэрч 2 зөвлөмж, нэмэлт санхүүжилтийн данснаас анхан шатны баримтын бүрдэлгүй хоолны мөнгө 1.1 сая төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тавигдсаныг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1.1	1	1.1	100
Албан шаардлага	0	0	0	0	100
Зөвлөмж	2	1.1	2	1.1	100
Нийт дүн	3	2.2	2	2.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жолоочийн тооцоо бодолт, эмийн тайлан зэрэг асуудлууд болон өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа¹ байхгүй болно.

Аудитаар нийт 490.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 443.2 сая төгрөгийн албан шаардлага өгч 45.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Ажилтан албан хаагчдын томилолтоор ажилласан хугацааны хоолны хөнгөлөлтийг суутган тооцоогүй хоолны хөнгөлөлтийг бүр бүтэн бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулах", Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал 1 дэх заалтад заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулах арга хэмжээ аваагүй, өдөрт ажиллах илүү цагийн дээд хязгаарыг баримтлаагүй, нэмэгдлийг бүх ажилчдад хавтгайруулан олгосонтой холбоотой 443.2 төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 84.4. "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна.", 109.1. "Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно." гэсэн заалтуудтай нийцэхгүй байх тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.4 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой байгууллагын хэрэгцээнд ашиглаж байгаа 2 нэр төрлийн 43.4 сая төгрөгийн автомашины үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчдэд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, ашиглах боломжгүй бол актлах асуудлыг шийдвэрлэх.

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 400 ширхэг сум 2.5 сая төгрөгөөр худалдан авч зарцуулсан. Хичнээн амьтан агнаж хэдэн сум зарцуулсан тооцоо бодож баталгаажуулаагүй, бөөн дүнгээр зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, зарцуулалтын тооцоо бодож баталгаажуулж ажиллах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээ нөхсөн ч ашиглаж байгаа хөрөнгийн тогтоогоогүй үнэ	1	43,400.0	0	0	0	0	1	43,400.0	0	0	0	0
Сумны тооцоо бодож баталгаажуулаагүй	1	2,540.0	0	0	0	0	1	2,540.0				
Илүү цагийн нэмэгдлийг ажилчдад хавтгайруулан олгосон	1	302,431.8	0	0	1	443,183.6	0	0	0	0	0	0
Хоолны хөнгөлөлт суутган тооцоогүй	1	1,197.0	1	1,197.0	0	0						
Дүн	4	490,320.6	1	1,197.0	1	443,183.6	2	45,940.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Ц.АЗЗАЯА